



“СИМПЛ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юнайтед Айр Файнэнс" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот

Утас: +976-70122346; info@uaf.mn

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Д.Баярсайхан /"Симпл Ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/



Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл.....	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл.....	5
4. Хавсралт - Аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт.....	6

1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Симпл Ассет ТЗК" ХХК нь 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Ашид Капитал ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Симпл Ассет ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, энгийн 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Д.Баярсайхан, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Э.Сэлэнгэ, ТУЗ-ийн гишүүнээр Б.Тэмүүлэн нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК ажиллаж байна.

"Симпл Ассет ТЗК" ХХК нь 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдөр 50 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Симпл Ассет ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011838466
Регистрийн дугаар	6852688
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/06/08
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	309
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	500,000
ХБҮЦ (сая төг.)	50,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	15.0%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК нь 2022 онд ХБҮЦ-ны хүүгийн төлбөрт 3.76 тэрбум төгрөгийг хуваарийн дагуу төлсөн бөгөөд үндсэн төлбөрийг төлж эхлээгүй байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үлдэгдэл	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	2023/03/23	50,000,000,000.00	-	1,849,315,068.49
2	2023/06/23	50,000,000,000.00	25,000,000,000.00	1,890,410,958.90
3	2023/09/23	25,000,000,000.00	-	945,205,479.45
4	2023/12/23	25,000,000,000.00	25,000,000,000.00	934,931,506.85
Нийт			50,000,000,000.00	5,619,863,013.70

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 17.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.06.23	2022.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	50,005,369,945.18	41,371,590,954.34	-17.3%
Зээлийн дундаж үлдэгдэл	3,222,203.10	2,757,003.26	-14.4%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	0.04%	0.05%	16.8%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	0.39%	0.45%	14.6%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	24.59%	24.44%	-0.6%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	4.63	8.16	76.1%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	18.08	12.18	-32.6%
Сарын дундаж төлбөрийн дүн	235,810.37	310,464.47	31.7%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	2,238,060.39	2,388,048.70	6.7%
Зээлийн тоо	15,519	15,006	-3.3%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	Иргэн	-
Чанаргүй зээлийн хувь	0.00%	2.73%	0.0%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс:	-	48,643,579,449.19*	-
Зээлийн үндсэн төлбөр	-	43,143,748,959.84	-
Хүүгийн төлбөр	-	5,494,656,937.35	-
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	5,166,035.00	-

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2022 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 8.65 тэрбум төгрөгийг гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

2022 оны эцсийн байдлаар “Симпл Ассет ТЗК” ХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 485.77 сая төгрөг байна.

“Юнайтед Айр Файнэнс” ХХК нь “Симпл Ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам”-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	7,839	-
2	Багцад нэмж бүртгэсэн	7,326	34,509,969,945.00
Нийт		15,165	34,509,969,945.00

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Симпл Ассет ТЗК” ХХК-ийг “Ашид Капитал ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Ашид Капитал” ББСБ ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн Хувьцаа эзэмшигчийн хурлын 01/1317 тоот шийдвэрээр Д.Баярсайхан, Б.Тэмүүлэн, Э.Сэлэнгэ нарын ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн Д.Баярсайхан ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 7 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2022.04.06	ТУЗ-ийн даргын томилох тухай	ТУЗ-ийн даргаар Д.Баярсайханыг томилов.
2	2022.04.07	Симпл Ассет ХХК-ийн чиглэлийн тогтоох тухай.	Компанийн чиглэлийг тогтоож УБЕГазарт холбогдох журмыг дагуу бүртгүүлсэн.
3	2022.04.13	ХБҮЦ гаргахтай тухай, ХБҮЦ гаргахтай холбоотой холбоотой гэрээ журмыг төслүүдийг батлах, хэлцэлд оролцох талуудыг сонгож гэрээ байгуулах тухай болон ХБҮЦ гаргахтай холбоотой материалыг Хороонд хүргүүлэх.	50 тэрбум төргөг хүртлэх үнийн дүн бүхий ХБҮЦ гаргах өргөдөл материалыг СЗХороонд хүрүүлсэн
4	2022.06.02	ХБҮЦ-ны хэлцэлтэй холбоотой гэрээ журмын төслийг батлах тухай.	Холбогдох журмыг батлав.
5	2022.06.10	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд данс нээлгэх, дансыг захиран зарцуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгох тухай.	Хадгаламжийн дансыг нээж захиран зарцуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгов.
6	2022.10.07	2022 оны 3-р улирлын санхүүгийн үйл ажиллагаа болон хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг батлах тухай	2022 оны 3-р улирлын санхүүгийн үйл ажиллагааны болон хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж 2022 оны 10 сарын 01-нд СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт мэдэгдсэн.
7	2022.12.09	Үнэт цаасны төлбөр цуглуулах төлбөр төлөх журам болон төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээнд өөрчлөлт оруулах тухай.	Холбогдох журам гэрээнд өөрчлөлт оруулж баталгаажуулан СЗХороонд мэдэгдэв.